

新型コロナウイルス感染症積極的疫学調査文例（日本語、モンゴル語） ver.1

2020年11月30日

令和2年度 地域保健総合推進事業
全国保健所長会グローバル研究班[※]作成

※「グローバルヘルスの保健所機能強化への活用方法確立および開発途上国に対する日本の衛生行政経験の伝達可能性の模索」研究班

以下は、保健所が、新型コロナウイルス感染症に関する積極的疫学調査を、外国籍の対象者に実施する場合に、参考にできる例文集です。必要時、自由にご活用ください。なお、翻訳ツールなどを用いて英語以外の各種言語に変換する場合は、日本語文からではなく英語文から各種言語に変換するとより適切に翻訳される可能性が高いと思われます。ご注意ください。

また、適宜『保健行政窓口のための外国人対応の手引き』（http://www.phcd.jp/02/t_gaikoku/）をご参照ください。

A) 自己紹介

Өөрийгөө танилцуулах

- はじめまして。わたしの名前は日本太郎です。
За танилцъя. (Би өөрийгөө танилцуулья) Намайг Нихон Таро гэдэг.
- わたしは、〇〇保健所の保健師です。
Би эрүүл мэндийн газарт ажилладаг эрүүл мэндийн ажилтан.
- わたしは、〇〇保健所の公衆衛生医師です。
Биэрүүл мэндийн газарт ажилладаг нийтийн эрүүл ахуйн эмч.
- わたしは、〇〇保健所の行政官です。
Би эрүүл мэндийн газарт ажилладаг төрийн албан тушаалтан.

B) 日本の保健所の説明

Японы эрүүл мэндийн газрын тухай танилцуулга

- 日本の保健所の役割は、あなたの国とは異なるかもしれませんが。
Японы эрүүл мэндийн газрын чиг үүрэг танай улсынхаас өөр байж магадгүй.
- 日本の保健所は、地域の皆さんの健康を守る重要な役割を担っています。食品衛生や、精神保健、結核や感染症の対策など、公衆衛生業務を行っています。
Японы эрүүл мэндийн газрууд бүс нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах чухал үүрэг гүйцэтгэдэг. Хоол хүнсний эрүүл ахуй, сэтгэцийн эрүүл мэнд, сүрьеэ өвчин болон бусад халдварт өвчний эсрэг арга хэмжээ зэрэг олон нийтийн эрүүл ахуйг хамгаалах чиглэлээр ажилладаг.
- ただし、日本の保健所は、あなたへの直接治療や薬の処方などの医療サービスは提供しません。

Харин Японы эрүүл мэндийн газрууд өвчтөнд эмчилгээ, эмийн жор олгох зэрэг шууд хэлбэрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэггүй.

8. 保健師とは、保健所などの行政機関で働いている看護職です。私たちは、地域の皆さんが健康で生活できるために、必要な支援を行っています。

Эрүүл мэндийн ажилтан гэж эрүүл мэндийн газар зэрэг төрийн байгууллагад ажилладаг сувилагч мэргэжилтэй хүнийг хэлнэ. Бид эрүүл мэндийн ажилтнууд орон нутгийн хүн амыг эрүүл энх амьдруулахын тулд шаардлагатай дэмжлэг үзүүлдэг.

9. 公衆衛生医師とは、保健所などの行政機関で働いている医師で、感染症対策に携わっています。感染症の疫学的状況を評価し、病気のさらなる拡散を防ぐための手段についてアドバイスを提供します。

Нийтийн эрүүл ахуйн эмч гэж эрүүл мэндийн газар зэрэг төрийн байгууллагад ажилладаг эмч бөгөөд халдварт өвчний эсрэг арга хэмжээний хэрэгжилтэнд оролцдог. Халдварт өвчний тархалтын байдалд эпидемиологийн үүднээс үнэлгээ хийж, өвчний тархалтыг зогсоох арга хэмжээний талаар зөвлөгөө өгч ажилладаг.

C) 検査に関する説明

Шинжилгээний тухай танилцуулга

10. (症状から・接触歴あり・行動歴あり・濃厚接触者である)ことより、あなたは COVID-19 の検査を受ける必要があります

(Шинж тэмдэгтэй/ Халдвартай өвчтөнтэй харьцсан/ Халдварын голомтоос ирсэн/ Ойрын хавьтал болох) учраас та Ковид-19-ийн шинжилгээнд хамрагдах шаардлагатай.

11. 検査は(喀痰採取・唾液採取・鼻咽頭スワブ採取・鼻腔自己採取・その他)により実施します。

Шинжилгээг (Цэр/ Шүлс/ Хамар, Хоолойн арчдас/ Бусад)-ын сорьц авч хэрэгжүүлнэ.

12. 検査結果は()時間/日ほどで出ます。結果が出るまでは、自宅などで待機して、なるべく人に合わないよう気をつけてください。

Шинжилгээний хариу нь цаг / хоногийн дараа гарна. Хариу гартал гэртээ өөрийгөө тусгаарлах хэрэгтэй ба хүнтэй уулзахаас аль болох зайлсхийнэ үү.

13. 検査結果が出るまで、病院で待機してもらいます。

Шинжилгээний хариу гартал та эмнэлэг дээр байх хэрэгтэй.

14. 陽性であれば入院となります。

Шинжилгээгээр эерэг (халдвартай) гарвал та эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болно.

15. 陰性であっても、2 週間ほどは健康状態に気をつけてください。体調不良となる場合は、保健所まで連絡ください。

Хэрэв шинжилгээгээр сөрөг (халдваргүй) гарсан ч 2 долоо хоногийн хугацаагаар эрүүл мэндийн байдалдаа онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Хэрэв цаашид биеийн байдалд өөрчлөлт гарвал эрүүл мэндийн газарт хандана уу.

D) 積極的疫学調査に関する説明

Халдварт өвчний идэвхтэй тандалт судалгааны тухай тайлбар

16. いわゆる「積極的疫学調査」とは、主に感染症が発生した地域の担当保健所が実施する調査です。この調査は、日本の感染症予防法に基づいて行われます。地域での感染拡大を防ぐために、アウトブレイクの全体的な状況、感染の推定原因、疾患の経過などを調べます。

“Халдварт өвчний идэвхтэй тандалт судалгаа” гэдэг нь гол төлөв халдварт өвчин тархсан бүс нутгийг хариуцдаг эрүүл мэндийн газраас хийдэг шинжилгээ юм. Тус шинжилгээ нь Японы Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд үндэслэн хийгддэг. Бүс нутагт халдварт өвчний тархалт нэмэгдэхээс сэргийлэхийн тулд цар тахлын ерөнхийлсөн байдал, халдварын шалтгааны таамаглал, өвчин эмгэгийн явц зэргийг судална.

17. あなたの個人情報は、日本の個人情報保護法に基づいて厳重に管理され、あなたのプライバシーは確実に保護されますので安心してください。

Таны хувийн мэдээлэл нь Японы хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуульд үндэслэн чанд хамгаалагдах ба таны хувийн чанартай мэдээлэл найдвартай хамгаалагдах тул санаа зовох хэрэггүй.

18. 皆様から得た貴重な情報に基づいて、新型コロナウイルス感染症の潜伏期間、感染経路、および感染源の推定などを行います。この調査結果は、新型コロナウイルス感染症に対するより良い対策に大きく貢献します。あなたのご協力に心より感謝いたします。

Та бүхний хамтын ажиллагаагаар олсон мэдээлэлд үндэслэн Ковид-19-ийн далд үе, халдвар дамжсан зам, халдварын эх үүсвэрийг таамаглах зэрэг ажил хэрэгжүүлнэ. Судалгааны үр дүн нь Ковид-19-ийн эсрэг арга хэмжээг боловсронгуй болгоход ихээхэн тус нэмэр болно. Хамтран ажилласан танд талархал илэрхийлье.

E) 新型コロナウイルス感染症の積極的疫学調査(最初の説明)

Ковид-19 халдварт өвчний тандалт судалгаа (анхны танилцуулга)

疑似症患者で「蓋然性が高い」場合

Сэжигтэй шинж тэмдэгтэй бөгөөд “халдвар авсан магадлал өндөр” байх тохиолдол

19. あなたは、渡航歴、接触歴、症状などから新型コロナウイルス感染症が強く疑われています。現在あなたの検体中にウイルスがいるかどうかを確かめる検査が実施されています。結果はまだ出ていませんが、念のため、あなたの最近の様子などをお聞かせください。

Та гадаад оронд зорчсон, халдвартай өвчтөнтэй харьцсан, шинж тэмдэгтэй зэрэг нөхцөл байдлаас үзэхэд Ковид-19-ийн халдвартай байх магадлал өндөр байна. Одоогоор танаас авсан сорьцод вирус байгаа эсэхийг шалгах шинжилгээ хийгдэж байна. Хариу нь гарах болоогүй хэдий ч ойрын үеийн таны биеийн байдал болон бусад байдлын талаар асуулга асуумаар байна.

患者確定例で有症状の場合

Халдвар авсан нь батлагдсан бөгөөд шинж тэмдэгтэй хүний хувьд

20. あなたは、発熱や呼吸症状があり、あなたから採取した検体の検査で新型コロナウイルスが検出されました。あなたは新型コロナウイルス感染症の確定患者と診断されています。この病気に関しては、まだ分からないことが多く、あなたがどのように感染したのかを考える必要があります。また、あなたから他の人にうつしていないかを追跡することも重要です。この調査にご協力ください。

Та халуурах болон амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй бөгөөд танаас авсан сорьцын шинжилгээгээр шинэ төрлийн коронавирусу илэрсэн байна. Иймд оношилгоогоор та Ковид-19 халдвар авсан нь батлагджээ. Энэ өвчний талаар хүн төрөлхтний хувьд хараахан судлагдаагүй зүйл олон байдаг бөгөөд таныг ямар замаар халдвар авсан гэдгийг судлах хэрэгтэй. Мөн танаас бусад хүмүүст халдвар тархсан эсэхийг тандах нь чухал юм. Иймд таныг энэ судалгаанд хамрагдахыг хүсэж байна.

患者確定例、無症状病原体保有者の場合

авсан нь батлагдсан бөгөөд шинж тэмдэггүй хүний хувьд

21. あなたは、血液中に新型コロナウイルスが検出されましたが、まだ何の症状も認めません。あなたは新型コロナウイルス感染の確定症例と診断されると同時に、「無症候性新規コロナウイルス感染症例」と診断されます。無症候例がこの病気を他の人に感染させるかどうかはまだ明らかではありません。また、あなたがどのように感染したのかもわたしたちは検討する必要があります。この調査にご協力ください。

Таны шинжилгээнээс шинэ төрлийн коронавирусу илэрсэн хэдий ч одоогоор ямар ч шинж тэмдэггүй байна. Та Ковид-19-ийн халдвар авсан нь батлагдсан бөгөөд “Шинж тэмдэггүй Ковид-19 өвчтөн” гэж оношлогдоно. Шинэ тэмдэггүй вирус тээгч нь бусад хүмүүст халдвар тараах эрсдэлтэй эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Түүнчлэн, таныг ямар замаар халдвар авсан гэдгийг бид сайн судлах хэрэгтэй. Иймд таныг энэ судалгаанд хамрагдахыг хүсэж байна.

濃厚接触者

Ойрын хавьтал

22. **あなたは、新型コロナウイルス感染症と診断された方と、濃厚に接触したと私たちは考えます。**

Таныг Ковид-19 халдвартай гэж оношлогдсон хүний ойрын хавьтал байна гэж бид үзэж байна.

23. **あなたは、新型コロナウイルス感染症が疑われる方と、濃厚に接触したと私たちは考えます。**

Таныг Ковид-19 халдвартай сэжиг бүхий хүний ойрын хавьтал байна гэж бид үзэж байна.

24. **最後に濃厚接触をした日から14日間は、あなたの健康状態に注意をしてください。もしあなたに発熱や呼吸器症状が現れた場合には、あなたが医療機関を受診する前に、必ず「帰国者・接触者相談センター」に電話連絡を入れてください。多言語対応の電話番号はXXです。**

Хамгийн сүүлд ойроор харьцсан өдрөөс хойш 14 хоногийн хугацаанд та эрүүл мэндийн байдалдаа онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Хэрэв та халуурах, амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрвэл эмнэлэг дээр очихоос өмнө заавал “Гадаад оронд зорчиж ирэгсэд ба ойрын хавьталд зориулсан зөвлөгөөний төв” рүү утсаар холбогдоно уу. Япон хэлээс өөр хэдэн төрлийн хэлээр холбогдох боломжтой утасны дугаар нь XX болно.

F) **新型コロナウイルス感染症の積極的疫学調査(具体的な調査項目)**

Ковид-19-ийн идэвхтэй тандалт судалгаа (Дэлгэрэнгүй судалгааны агуулга)

25. **これからあなたにいくつか質問をします。質問は、1)あなたに関する情報と2)あなたの行動に関する情報の二つの種類に分かれます。もしわからないことがあれば、いつでも尋ねてください。**

Ингээд танаас хэдэн асуулт асууна. Асуултууд нь гол төлөв 1) таны тухай мэдээлэл, 2) таны ойрын үед хийсэн үйлдэл, хөдөлгөөний тухай гэсэн хоёр зүйлээс бүтнэ. Хэрэв тавигдсан асуулт ойлгомжгүй бол тодруулж асууна уу.

26. **すでに他の医療従事者があなたに尋ねた質問と似た質問をわたしたちが尋ねるかもしれませんが、どうぞご容赦ください。**

Эрүүл мэндийн үйлчилгээний бусад ажилтнуудын асуусан асуултуудыг давтаж асууж магадгүй тул уучлалт гуйя.

1) **あなたに関する情報**

Таны тухай мэдээлэл

年齢

Нас

27. **あなたの年齢をお聞きできますか？**

Та хэдэн настай вэ гэдгийг асууж болох уу?

居住地

Оршин суугаа газар

28. あなたの住所をお聞きできますか？

Та хаягаа хэлнэ үү.

症状・経過

Өвчний байдал, явц

29. あなたは、どんな症状がありますか？

Танд ямар шинж тэмдэг байна вэ？

30. あなたの熱が出たのはいつからですか？

Хэзээ халуурч эхэлсэн вэ？

31. あなたの咳が出たのはいつからですか？

Хэзээ ханиалгаж эхэлсэн вэ？

32. あなたの息苦しさが出たのはいつからですか？

Амьсгал давчдах мэдрэмж хэзээнээс төрсөн вэ？

33. あなたのその症状は、どのくらいの間、続いていますか？

Таны энэ шинж тэмдэг хэр удаан хугацаагаар үргэлжилж байна вэ？

2) あなたの行動に関する情報

Таны ойрын үеийн үйлдэл, хөдөлгөөний тухай мэдээлэл

渡航歴・滞在歴

Гадаад оронд зорчсон болон саатсан түүх

34. あなたは、過去 2 週間以内に COVID-19 の流行地域に行きましたか？

Та өнгөрсөн 2 долоо хоногийн дотор Ковид-19 халдварын голомттой бүс рүү зорчсон уу？

35. (行っていた場合)それはどこですか？

(Хэрэв очсон бол) Хаана очсон вэ？

36. あなたはいつ流行地域に滞在しましたか？

Та халдварын голомттой бүсэд хэзээ саатаж байсан бэ？

接触歴

Халдвартай өвчтөнтэй харьцсан түүх

37. あなたは、過去 2 週間以内に COVID-19 の患者または感染が疑われる人と接する機会がありましたか？

Та ойрын 2 долоо хоногт Ковид-19-тэй өвчтөн эсвэл халдвар авсан сэжигтэй хүнтэй харьцсан уу?

参考資料

- 新型コロナウイルス感染症患者に対する積極的疫学調査実施要領(暫定版)
<https://www.niid.go.jp/niid/images/epi/corona/2019nCoV-02-200206.pdf>
- 阿彦忠之ほか、アウトブレイクの健康危機管理、医学書院P150-153
- 全国保健所長会グローバル研究班、保健行政窓口のための外国人対応の手引き、第2版(未定稿)